

ЦАХИМ СУРГАЛТЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ, АРГА ЗАМ

Б.Доржпүрэв, Ц.Номин-Эрдэнэ
Дорнод их сургууль
dorjpurev.b@dornod.edu.mn
ts.nominerdene@dornod.edu.mn

Хураангуй

Мэдээлэл, холбооны технологийн үсрэнгүй хөгжил олон салбарт хувьсал хийсний нэг нь боловсрол. Интернэтээр дамжуулан мэдлэг, боловсрол олгох цахим сургалтын (e-learning) хэлбэрийг сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд өргөн ашиглах болсон цахим сургалт бол өнөө цагт зайн сургалтын (distance learning) үндсэн хэлбэр болоод байна.

Цахим сургалтыг зохион байгуулах нь олон эрсдэлээс урьдчилан сэргийлж, мөн үүний хажуугаар олон давуу талуудыг бидэнд харуулсаар байна.

Монгол улс даяараа цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой нэгдсэн цахим сургалт явуулах шийдвэр гарсантай холбоотой Дорнод их сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн 2-р улирал нь бүтэн цахим сургалтаар зохион байгуулагдсан тул судлаач бид 2-4 дамжааны бүх мэргэжлийн бүх ангийн, дамжаа бүрийн төлөөлөл болгон 70 гаруй оюутнуудыг түүвэрлэн судалгаанд хамрууллаа. Ямар ч нөхцөл байдал, асуудал тулгарсан үед бид сургалтын үйл ажиллагааг тасалдуулан, доголдуулахгүйн тулд цахим сургалтыг улам бүр боловсронгуй болгох тал дээр анхаарч ажиллах цаг үе нэгэнт ирсэн нь энэ сэдвийг судлах хэрэгцээ шаардлагатай байгааг харуулж байна. Дорнод их сургуулийн цахим сургалтын чанар, хүртээмжийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, улмаар хэрхэн сайжруулах боломжтой талаарх арга замыг тодорхойлон санал гаргах, хэрэгжүүлэх зорилго тавьлаа.

Түлхүүр үг: Суралцахуй үйл, оюутан, цахим сургалт, хувь хүний хөгжил

Оршил

Зайн сургалтын суурийг 1800-аад оны үед Англид тавьсан бөгөөд багш, суралцагч хоёр ердийн шуудангаар сургалтын үйл ажиллагаанд оролцдог байжээ. Зайн сургалтыг цахим хэрэгсэл болох интернэт, мэдээлэл, харилцааны технологийг ашиглан явуулснаар танхимд биечлэн ирэх боломжгүй суралцагчид мэдлэг, боловсролыг түгээдэг. Харин Монгол улсад зайн сургалтыг хөгжүүлэх, цаашлаад бүрэн тогтолцоог хөгжүүлэх эхлэл тавигджээ. (Д.Догсом, 2018)

Цахим сургалт нь зайны сургалтын нэгэн төрөл боловч уламжлалт танхимийн сургалтын олон шинжийг өөртөө агуулсан байдаг. Өөрөөр хэлбэл дээр дурьдсан сургалтуудын аль алиных нь залгамжчанаар цахим сургалтад бий. Цахим сургалт нь технологид суурилсан сургалтын ерөнхий нэр

томьёо. Мөн урьдчилан боловсруулсан цахим сургалтын материалаар, цаг хугацаа, орон зайг мэдээлэл, холбооны технологи ашиглан даван туулж, суралцагч багшийн дэмжлэгтэйгээр мэдлэг, боловсрол эзэмшдэг. (Т.Сувдмаа, 2005 он)

Хүний харах мэдрэхүйгээрээ хүлээж авсан мэдээлэл сонсох мэдрэхүйгээр хүлээн авсан мэдээллээс илүү үнэмшилтэй байдгийн зэрэгцээ бат тогтож, удаан мартагддаг тул сургалтанд мэдээлэл харилцаа холбооны технологийг, тэр дундаа мультимедиа технологийг ашиглах нь хийсвэр ухагдахуунууд болон төсөөлж, харахад төвөгтэй зүйлсийг бодит юм шиг харагдуулж, амьдруулдгаараа хичээлийг ойлгомжтой, илүү сонирхолтой болгоод зогсохгүй, онолын хэсгийг заах хугацааг багасгаж суралцагчдын дадлага хийх цагийг нэмэгдүүлдэг. Мөн Цахим сургалт буюу E – Learning –ны талаар олон маш олон тодорхойлолт, үзэл баримтлал байдаг. Цахим сургалт нь интернэт ба сургалтын нийлбэр цогц болно.

Зорилго: Дорнод их сургуулийн цахим сургалтын чанар, хүртээмжийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, улмаар хэрхэн сайжруулах боломжтой талаарх арга замыг тодорхойлон санал гаргах, хэрэгжүүлэх

Зорилт

- Дорнод их сургуулийн цахим сургалтын чанар, хүртээмжийг тодорхойлох судалгааг оюутнуудаас авах
- Судалгааны үр дүнг нэгтгэн дүнгэж, анализ хийн, дүгнэлт гаргах
- Гаргасан дүгнэлтэд үндэслэн цаашид хэрхэн сайжруулж болох боломж, арга замыг тодорхойлж санал гаргах

Судалгааны арга ба түүвэр: Энэхүү судалгааг асуулгын аргаар авахдаа санамсаргүй түүврийн аргаар google forms асуулга ашиглан цахимаар / Дорнод их сургуулийн хэмжээнд/ 21 хоногийн турш өгөгдөл цуглуулж, нийт 70 гаруй оюутан оролцсон. Түүврийг сонгон авахдаа судалгаанд оролцоход бэлэн байгаа байдал, хүсэл эрмэлзлэлийг нь шалгуураа болгосон.

Баримт бичгийн судалгааг онлайн ба мэдээллийн эх сурвалжууд болох ном, сурах

бичиг болон гадаад, дотоодын судлаачдын судалгаанаас судалгаа хийж нэгтгэн дүгнэлээ.

Судалгааны арга зүй


Цахим сургалтын чанар, хүртээмжийг тодорхойлох, цаашид сайжруулах боломжийг судлах зорилгоор хийсэн судалгаа нь оюутнууд цахим сургалтад хамрагдах үед ямар хүндрэл, бэрхшээл тулгарсан, сургалтын чанар, хүртээмжтэй байдал, ойлгомжтой байсан эсэхийг асуумжийн аргаар тодорхойллоо.

Судалгааны үр дүн

Монгол улс даяараа цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой нэгдсэн цахим сургалт явуулах шийдвэр гарсантай холбоотой Дорнод их сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн 2-р улирал нь бүтэн цахим сургалтаар зохион байгуулагдсан тул судлаач бид 2-4 дамжааны бүх мэргэжлийн бүх ангийн, дамжаа бүрийн төлөөлөл болгон 70 гаруй оюутнуудыг түүвэрлэн судалгаанд хамрууллаа. Судалгаанд Байгалийн ухаан, бизнесийн салбарын оюутнуудын эзлэх хувь 47% байсан бол Нийгэм, хүмүүнлэгийн салбарын оюутнууд үлдсэн 53%-ийг эзэлж байна. Судалгаанд оролцогчдыг хөтөлбөрөөр нь ялгавал Нягтлан бодох бүртгэл, Газрын тосны инженер, Бизнес менежмент, Багш-Бага анги, Багш-Сургуулийн өмнөх боловсрол, Багш-Англи хэл, Орчуулга Хятад хэл, Нийгмийн ажил, Багш-Урлагийн боловсрол, Багш-монгол хэл, уран зохиол гэх мэт нийт 10 мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудыг судалгаанд хамрууллаа. Нийт судалгаанд хамрагдсан оюутнуудыг курсээр нь ялган хувьчилбал, 4-р дамжаа 45,5%, 3-р дамжаа 36,4%, 2-р дамжаа 18,2%-ийг эзэлж байна.


Оюутнуудаас "Цахим хичээл сонирхолтой, ойлгомжтой, үр дүнтэй байсан эсэх" гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын 4,5% буюу маш бага хувь "маш хангалттай" гэсэн хариулт өгсөн бол "дунд зэрэг" гэсэн хариултыг ихэнх хувь болох 57,6% нь өгсөн байна. Харин "Хангалтгүй" гэсэн хариултыг 15,2% нь өгсөн бол "хангалттай" гэсэн хариултыг 22,7% нь сонгосон байна. Үүнээс үзэхэд цахим хичээлийн ойлгомжтой, үр дүнтэй, хүртээмжтэй байдал нь "Хангалтгүй" түвшинд байгаа нь харагдаж байна. /зураг №1/

Цахим хичээл сонирхолтой, ойлгомжтой, үр дүнтэй байсан эсэх.
66 responses



/Зураг №1/

Хичээлүүд цахим хэлбэрээр бүрэн явагдсан эсэх.
66 responses




/Зураг №2/

Лекц болон семинарын хичээл хүртээмжтэй байсан эсэх гэсэн асуултад оюутнуудын 30% нь "хангалттай", 7,8% нь "хангалтгүй" гэсэн хариултыг сонгосон ба лекцын хичээл болон семинарын хичээлийн хүртээмжийн талаарх асуултад хариултын хувь, хэмжээ нь ижил үр дүнтэй хариулт ирсэн байна. Анхаарууштай хариулт нь хамгийн бага хувь буюу 4,5% нь "маш хангалттай" гэжээ.

Цахим хичээлүүдэд бие даалтын ажлын даалгавар өгөгдсөн болон гүйцэтгэх явцад оюутнуудын 58,6% нь бие даалтын даалгаварын оновчтой өгөгдсөн эсэхэд "дунд зэрэг" гэсэн хариулт өгч байгаа нь анхаарах шаардлагатайг илтгэж байна. /Зураг №3/ даалгаваруудыг гүйцэтгэх явцад ашиглах материалуудын талаарх "номын сангаас авч хэрэглэсэн нь 16,7%, оюутнуудад цахим хичээлийн даалгаварыг гүйцэтгэхэд ашиглах ном, сурах бичиг, материалууд хомс байгаа нь ажиглагдаж байна.


Бие даалтын ажлууд оновчтой, ойлгомжтой өгөгдсөн эсэх.
66 responses



/Зураг №3/

Цахим хичээлийн даалгаврыг гүйцэтгэх явцад нэмэлт ном, сурах бичиг, материалуудыг хаанаас авч ашиглаж байсан бэ?

66 responses




/Зураг №4/

Цахим хичээлийн хэлбэрийн 71,2% нь power point илүү ойлгомжтой, хүртээмжтэй байсан ба бусад нь facebook групп, zoom, youtube, live-аар орсон хэлбэрүүдийг сонгосон байна. /Зураг

№5/ Мөн багш ямар хэлбэрээр цахим хичээлээ зохион байгуулж байсан талаарх асуултад дээрх хариулттай адил түвшинд хариулсан бөгөөд нэмэлтээр word, excel, video lesson, Zoom, TV lesson, PDF гэсэн хэлбэрүүдийг ашиглаж байсан гэсэн хариултуудыг өгсөн. Үүнээс үзэхэд багш хичээлээ маш олон төрөл, хэлбэрүүдийг сонгон боловсруулж буй нь харагдсан. /Зураг №8/

Ямар хэлбэрээр зохион байгуулагдсан хичээл хамгийн үр өгөөжтэй, ойлгомжтой, байсан бэ?


66 responses



/зураг №5/

Багш цахим хичээлээ ихэвчлэн ямар хэлбэрээр зохион байгуулж байсан бэ?

66 responses




/зураг №6/

Цахим хичээлд хамрагдаж, лекц болон семинарын хичээл, багштайгаа шууд холбогдож шалгалт өгөх болон диплом, төсөлт ажлын хамгаалалтын үед оюутнуудад мэдээлэл технологийн мэдлэг, чадвар хангалттай эсэх асуултад “маш хангалттай” гэж 10%, тал хувь нь “хангалттай” мэдлэг чадвар байсан гэж үзсэн бол 35% нь “дунд зэрэг”, цөөнх хувь нь “хангалтгүй” болон “огт хангалтгүй” гэж хариулжээ. /Зураг №7 /

Цахим хичээлд хамрагдахад таны мэдээлэл технологийн мэдлэг, чадвар хангалттай байсан эсэх.

66 responses




/Зураг №7/

Цахимаар зохион байгуулагдсан хичээлүүдийн үнэлгээний асуулдалд судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын 48,5% нь “Зарим тохиолдолд” үнэлгээ оновчтой байсан гэж хариулсан бол 30% нь “оновчтой”, 13,6% нь “оновчгүй”, 7,5% нь “мэдэхгүй” гэж дүгнэжээ. /зураг №8/ Үүнээс үзэхэд тал хувь нь зарим тохиолдолд үнэлгээ оновчтой байсан гэж үзсэн учраас бидэнд анхаарах асуудал гэж харагдаж байна.

Цахим хичээлүүдийн ҮНЭЛГЭЭ оновчтой байсан эсэх.

66 responses



/Зураг №8/

Цахим сургалтын үед хамгийн чухал нь багш, оюутны харилцаа холбоо тогтоож, амжилттай суралцаж буй байдал юм. Ийм учраас доорх асуултыг судалгаандаа оруулсан. Оюутнуудаас “маш хангалтгүй” гэсэн хариулт цөөнх хариулсан бөгөөд “хангалтгүй” гэж 15,2% , “дунд зэрэг” гэж 36,4% үзсэн нь бид оюутантайгаа ажиллах, харилцаа холбоог тогтмол байлгах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт

Цаг үеийн нөхцөл байдал /COVID-19/ -аас шалтгаалан Дорнод их сургуулийн хувьд багш нарын цахим Google Classroom-оор явуулсан цахим сургалтын чанар, хүртээмж “дунд зэрэг” үр дүнтэй байна. Цахим хичээлийн ойлгомжтой, үр дүнтэй, хүртээмжтэй байдал, оюутнуудад цахим хичээлийн даалгаврыг гүйцэтгэхэд ашиглах ном, сурах бичгийн хүрэлцээ зэрэг нь “хангалтгүй” түвшинд байна.

Цахим сургалтын үеийн багш, оюутны харилцаа холбоо тогтоох зэрэг асуултуудад оюутнууд “дунд зэрэг” гэж хариулсан байна. цахим сургалтын давуу болон сул талыг тодруулах нээлттэй асуултанд хувь хүний хэд хэдэн чадваруудад ахиц гарсан явдал нь цахим сургалтын давуу талыг илэрхийлж байна. Мөн цахим сургалтын сул талууд харагдаж байгаа боловч засан сайжруулах боломж байгаа нь судалгаагаар харагдаж байна.

Санал

Энэхүү судалгааны үр дүн ба Нээлттэй асуултын хариулт зэргээс үндэслэн Багш нар видео хичээл бэлтгэж сургалтдаа ашиглах, цахим хичээлийн бие даалтыг интеграцлах, цахим ном, сурах бичгийн хүрэлцээг нэмэгдүүлэх, гарын авлага боловсруулж оюутнуудад сургалт явуулах, хичээлийг цахим сургалтад бүрэн шилжүүлэх, Багшийн нарын мэдээлэл технологитой ажиллах, ур чадварын сургалт, ЭША зохион байгуулах,

цахим сургалтын платформыг боловсронгуй болгох, иж бүрэн цахим хичээлийн уралдаан зарлах гэх мэт саналуудыг тусгаж байна.

WAYS TO IMPROVE THE QUALITY AND ACCESSIBILITY OF E-LEARNING

(example of dornod university)

Abstract

E-learning is being more widely used in the modern world, while traditional (teacher-centered) or classroom learning was common in the middle of the 20th century. The rapid growth of IT use is requiring modernization in the forms of teaching and methods in any stage of education.

Professors of Dornod University organized their classes online using Google Classroom during the semester. In the past, professors of the university have a few experiences of organizing some classes online, but they have never fully computerized the lessons throughout a whole semester, and the students didn't even study the lessons online for such a long term. Although the sudden government decision was difficult for both parties, the e-learning had been managed successfully.

Nowadays getting an education is more liberalized that meets the needs and interests of students and allows them to choose their own learning environment, pace, and duration of the study.(Tsedevsuren 2017). Similarly, e-learning has faced many requirements, such as good quality, accessibility, and comprehensibility when reaching students. In this study, we surveyed students of Dornod University to determine the quality and availability of online courses, conducted in the second term of the last academic year.

The purpose of this study is to provide feedback on what measures can be taken to improve the quality and accessibility of e-learning in the future, as well as other options and methods.

Key words: learning, e-learning, student, accessibility, quality

Зохиогчдын тухай

1. Батсүхийн Доржпүрэв, төгссөн сургууль: Чингис хаан дээд сургууль. Судалгааны ажлын туршлага: Аялал жуулчлал, менежментийн чиглэлээр олон улс, улс, бүс, орон нутагт 40 гаруй илтгэл, өгүүлэл бичсэн.
2. Цогтбаатарын Номин-Эрдэнэ, төгссөн сургууль: Монгол улсын их сургууль, судалгааны ажлын туршлага: жил бүр 2-3 судалгаа, өгүүлэл бичиж хэвлүүлж, хэлэлцүүлж байсан. /олон улс, улс, бүс, орон нутагт/ /Нийтдээ 10 гаруй судалгааны ажил, төсөл хөтөлбөр/ Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан.

Ном зүй:

1. Дорсом Д. (2018, 05 21). Монцамэ.мн. Retrieved from Монголын мэдээ: <https://montsame.mn/mn/read/90502>
2. Сувдмаа Т. (2005) Цахим сургалт. УБ хот: Соёмбо принт
3. Цэдэвсүрэн, Д. (2017). Цахим сурах бичиг боловсруулах онол, аргазүй. УБ хот:Битпрэсс ХХК.